

АХБ-ны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ)-ний төслийг хэлэлцэх Бүс нутгийн зөвлөлдөх уулзалт

*Зүүн Ази, Зүүн Өмнөд Ази, Шинэ Зеланд, Австралийн
Иргэний нийгмийн байгууллагууд*

2024 оны 2 дугаар сарын 5, 7, 9 | Цахим хурал



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE

The views expressed in this presentation are the views of the author/s and do not necessarily reflect the views or policies of the Asian Development Bank, or its Board of Governors, or the governments they represent. ADB does not guarantee the accuracy of the data included in this presentation and accepts no responsibility for any consequence of their use. The countries listed in this presentation do not imply any view on ADB's part as to sovereignty or independent status or necessarily confirm to ADB's terminology.

Үр дүнтэй зөвлөлдөх үйл ажиллагааг хангах АХБ-ны чиг шугамыг дахин нотлох нь

Хамгааллын бодлогын тойм, шинэчлэлтийн зөвлөлдөх уулзалт нь АХБ-ны БОНХ-ний төслийн талаарх байр суурь, санал бодлоо хамгийн үр дүнтэй байдлаар илэрхийлэх боломжийг оролцогч талуудад олгодог.

Ийм зөвлөлдөх уулзалтын үеэр бүх оролцогч талууд оролцоо, санал бодлоо илэрхийлэхийг дэмжинэ. Оролцогч талууд энэхүү хурлын үеэр хэлэлцүүлгийн явцыг баримтжуулах зорилгоор (Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөний 47-р зүйлд дурдсанчлан) видео болон аудио бичлэг хийлгэхийг зөвшөөрч байна. Бичлэгийг нийтэд нээлттэй нийтлэхгүй болно. АХБ нь ил тод байдлыг хангах үүднээс энэхүү хэлэлцүүлгийн хураангуйг Хамгааллын бодлогын шинэчлэл (SPRU)-ийн цахим хуудсанд нийтэлнэ.

Ийм бичлэгээс өөрийгөө хасуулах хүсэлтэй оролцогчид энэхүү хэлэлцүүлгээс хойш 2 долоо хоногийн дотор Хамгаалалтын бодлогын шинэчлэлийн Ажлын албанд safeguardsupdate@adb.org хаягаар хандана уу.

Бүх төрлийн санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлж болно. Эдгээрийг хонзогнох, зүй бусаар ашиглах эсвэл бусад байдлаар ялгаварлан гадуурхах зорилгоор ашиглахгүй.

Хэлэлцүүлгийн явцад нийтлэх, бичлэг хийх, нууцлал, болзошгүй эрсдэл, зүй бусаар ашиглах, ялгаварлан гадуурхах зэрэг аливаа асуудлаархи болгоожмжлол, зовнил байваас Ажлын албанд safeguardsupdate@adb.org хаягаар имэйл илгээнэ үү.

Хурлын зорилго

1. Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ) баримт бичгийн төслийн үндэслэл, тоймыг танилцуулах:
 - БОНХ-ний төслийн үндэслэл ба тойм
 - Санал болгож буй Байгаль орчин, нийгмийн стандартын тойм
 - Санхүүжилтийн хэлбэр, бүтээгдэхүүнүүдэд БОНХ-ийн талаар тавигдах шаардлагуудын тойм, Хөрөнгө оруулалт хийхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт (PIAL)
2. БОНХ-ний төсөлд санал авах, үүний дотор хамгааллын арга хэмжээг сурталчлах, олон нийтийг оролцуулах талаар туршлагаа хуваалцах

Хөтөлбөр (2 дугаар сарын 5)

| | |
|-------|--|
| 09:05 | Нээлтийн үг |
| 09:10 | Хуралдаан 1: БОНС болон БОНБ-ын тойм |
| 09:35 | Чиглүүлэгтэй хэлэлцүүлэг |
| 10:10 | Завсарлага |
| 10:15 | Хуралдаан 2: БОНС 1 болон БОНС 10-ын тойм |
| 10:25 | Чиглүүлэгтэй хэлэлцүүлэг |
| 11:55 | Нэгдсэн дүгнэлт, үнэлгээ, зар |

НЭЭЛТИЙН ҮГ

Брюс Данн

*АХБ-ны Хамгааллын алба (OSFG)-ны
Бодлого, техникийн үйлчилгээ хариуцсан
захирал*



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



Хуралдаан 1: Хамгааллын бодлогын тойм болон Филиппинд болсон өмнөх зөвлөлдөх уулзалтын үеэр гарсан саналууд; БОНХ болон БОНБ-ын тойм

Брюс Данн

*АХБ-ны Хамгааллын алба (OSFG)-ны
Бодлого, техникийн үйлчилгээ хариуцсан захирал*

Такако Морита, АХБ-ны Хуулийн алба (OGC)-ны Тэргүүлэх хуульч



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



Хамгааллын бодлогыг нягтлах, шинэчлэх зорилго



Бодлогын түвшинд хийсэн бэлтгэл ажил

ADB

1. 18 сэдэвчилсэн судалгааг хийж дуусгасан

- ✓ Бодлогын бүтэц, орчин, нийгэм, жендерийн асуудлууд.
- ✓ АХБ болон ОТХБ-уудын жишиг
- ✓ Хэрэгжиилтийн туршлага, сорилтууд

2. Оролцогч талуудын оролцоо

- ✓ **3600+** (нийт) хүнтэй зөвлөлдсөн
- ✓ **80** цахим зөвлөлдөх уулзалт (сэдэвчилсэн судалгаагаар)
- ✓ **10** ХБГО-нд очиж/оролцуулан хэлэлцүүлэг хийсэн
- ✓ **56** хувийн хэвшлийн харилцагчидтай зөвлөлдсөн
- ✓ **9** төслийн хэлэлцүүлэгт шууд өртөгсдийг ороцуулсан
- ✓ **10+** фокус бүлгийн хэлэлцүүлгийг жендер/БЧХЖБ-ны асуудлаар зохион байгуулсан
- ✓ Уугуул иргэдийн зөвлөх бүлгийг байгуулсан
- ✓ ОТХБ-уудтай яриа хэлэлцээ өрнүүлсэн

3. АХБ-ны ажилтнууд, Захирлуудын зөвлөлийн оролцоо

- ✓ Удирдах хороо, Ахлах зохицуулах бүлгүүд, Техникийн ажлын хэсгүүд
- ✓ Захирлуудын зөвлөлийн албан бус семинар (2020), Гүнзгийрүүлсэн хэлэлцүүлэг (2021, 2022), хоёр талын уулзалтууд



Хөгжиж буй гишүүн орнууд (ХБГО)-ад хийсэн хэлэлцүүлэг

1. Тонга
2. Папуа Шинэ Гвиней
3. Монгол
4. БНХАУ
5. Пакистан
6. Маршаллын Арлуудын БНУ
7. Филиппин
8. Энэтхэг
9. Индонез
10. Гүрж

Оролцогч талуудын оролцоо ба зөвлөлдөх хэлэлцүүлэг



Safeguard Policy Review | Asian Development Bank

www.adb.org

Оролцогч талуудаас ирүүлсэн саналын товчоон



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE

ХБГО-ууд

- Хамгааллын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх.
- ХБББ-ийн хэрэгжилтэд зарим бэрхшээлүүд оршсоор байна.
- Хэлцлийн шаардлагагүй зардлаас зайлсхийх.
- Хамгааллын үндэсний тогтолцоо (ХҮТ)-той илүү нягт уялдааг дэмжих.
- ОТСБ-уудын бодлого, дүрэм журмын уялдааг сайжруулах замаар хэлцлийн зардлыг бууруулах.
- Улс орон болон төслийн хувьд эхний шатнаас нь сайтар удирдамжаар ханган, чадавхийг сайжруулах дэмжлэг үзүүлэх.


ИНБ-ууд

- Хамгааллын шаардлагуудыг сулруулахгүй байх.
- Хийдэл болон ХҮТ-г ашиглаж болзошгүй зовнил
- Оролцогч талуудын оролцоо, ил тод байдлыг сайжруулах.
- Аюулгүй орон зайг хангаж, хонзогнох эрсдэлийг арилгах.
- Санхүүгийн зуучлагчдад тавигдах хамгааллын шаардлага санаа зовоодог.
- Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдал, жендэр, эмзэг бүлэг, бэлгийн чиг хандлага ба жендэрийн баримжаа, хөдөлмөрийн асуудал, уугуул иргэдийн асуудалд анхаарал хандуулах.
- Хүний эрхийн магадлан шинжилгээг тусгах.

Хувийн хэвшил

- Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ын гүйцэтгэлийн стандарт ба Экваторын зарчмуудад нийцүүлэх.
- УОХТ болон үндэсний шаардлагуудтай илүү нягт уялдуулах
- Ил тод мэдээлэх шаардлагыг ОУСК болон бусад олон талт санхүүгийн байгууллагууд (ОТСБ)-тай уялдуулах (жишээ нь, БОНБҮ-г 120 хоногийн дотор нийтэлдгийг 60 хоног болгон бууруулах)
- Тавигдах шаардлагуудыг илүү тодорхой болгох, зааварчилгаа өгөх; бэлтгэх, хэрэгжүүлэх явцад техникийн дэмжлэг үзүүлэх

Бэлтгэл ажлын график төлөвлөгөө



Зорилтууд:

- **АХБ-ны ажилтнууд болон зээлдэгч/харилцагчид БОНХ-г бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвар, чадавхи, дэмжих удирдамж заавраар хангагдах.**

Хөтөлбөрийн цаглабар:

- **Захирлуудын зөвлөл бодлогыг баталснаас хойш 12 сарын дараа БОНХ хүчин төгөлдөр болно (2025 оны 2-р улирал гэхэд)**
- Бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 2023 онд эхэлж, Удирдах зөвлөл баталсны дараа 3 жил үргэлжилнэ.

Хөтөлбөрийн үйл ажиллагаа:

- Шилжилтийг дэмжих үүднээс ХБГО-ууд болон хувийн хэвшлийн харилцагчдад зориулсан **чадавхийг бэхжүүлэх 3 жилийн иж бүрэн төлөвлөгөө боловсруулах**
- **Ажилтнуудад зориулсан хэрэгжүүлэх журам** - Үйл ажиллагааны гарын авлага, ажилтнуудад өгөх заавар
- БОНС болон сонгосон сэдвүүд тус бүрээр **удирдамж заавар боловсруулах, хэлэлцүүлэх.**
- **Сургалтын материалууд** – ХБГО-ууд, хувийн хэвшлийн харилцагчид болон бусад оролцогч талуудадад БОНС-ын шаардлагуудыг хэрэгжүүлэхэд зориулагдана (цахим сургалт, видео, сургалтын хөтөлбөр, загвар гэх мэт)
- Ажилтны **магадлан итгэмжлэл**, бусад оролцогч талуудад зориулсан гэрчилгээ олгох хөтөлбөр

INTERNAL. This information is accessible to ADB Management and staff. It may be shared outside ADB with appropriate permission.

Оролцогч талуудыг оролцуулах

- Шинэ бодлогыг бүх гол оролцогч талуудад хүргэх.
- Сургалтын хөтөлбөрүүдийг цахимаар болон биечлэн хэрэгжүүлэх
- Гүйцэтгэгч, хэрэгжүүлэгч агентлагууд, хувийн хэвшлийн харилцагчдад чиглэх
- ИНБ-ууд зэрэг бусад оролцогч талуудад зориулсан чиглүүлэх хөтөлбөрүүд
- Төслийн дэмжлэгээр нэмэлт төсөл хэрэгжүүлэх
- Улс орны хөтөлбөртэй уялдуулах, өргөн хүрээнд чадавхийг бэхжүүлэх.
- Чадавхийг бэхжүүлэх, хэрэгжилтийг бэхжүүлэх зорилгоор үндэсний байгууллагууд, ИНБ-уудтай түншлэлийг хөгжүүлэх.

БОНХ-ний тойм



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



Бодлогын санал болгож буй бүтэц

Байгаль орчин, нийгмийн хүрээ

Байгаль
орчин
нийгмийн
хүрээ



Байгаль орчин, нийгмийн стандартууд (БОНС)

ХБББ-ын одоогийн шаардлагууд дээр тулгуурлан санал болгож буй 10 стандарт



1
Байгаль орчин,
нийгмийн эрсдэл,
нөлөөллийн
үнэлгээ ба
менежмент

2
Хөдөлмөр эрхлэлт
ба хөдөлмөрлөх
нөхцөл

3
Нөөцийг
хамгаалах,
бохирдлоос
сэргийлэх

4
Эрүүл мэнд,
аюулгүй
ажиллагаа,
аюулгүй
байдал

5
Газар чөлөөлөх,
газар
ашиглалтыг
хязгаарлах

6
Биологийн олон
янз байдал,
байгалийн
нөөцийн
тогтвортой
менежмент

7
Нутгийн уугуул
иргэд

8
Соёлын
өв

9
Уур
амьсгалын
өөрчлөлт

10
Оролцогч
талуудын оролцоо,
мэдээллийн ил тод
байдал

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОН-ийн бодлого)

АХБ-ны хүлээх үүрэг


БОН-ийн бодлого нь: (i) бодлогын зорилтууд; (ii) хамрах хүрээ; (iii) АХБ-ны үүргээс бүрдэх бөгөөд, үүнд:

1. Зээлдэгч/харилцагчтай зөвшилцөн **байгаль орчин, нийгэм (БОН)-ийн эрсдлийн ангиллыг** боловсруулах
2. Зээлдэгч/харилцагчийн хийсэн **БОН-ийн үнэлгээг** эрсдэлийн шинж чанар, цар хүрээтэй дүйцүүлэн нягтлах
3. БОН-ийн эрсдэлд тохирсон **үнэлгээ, удирдлагын хэрэгслийг** тодорхойлоход нь Зээлдэгч/харилцагчдад туслах
4. **БОН-ийн тогтолцоо, гүйцэтгэлээ сайжруулахад нь** Зээлдэгч/харилцагчдад дэмжлэг үзүүлэх
5. Төслийг санхүүжүүлэх АХБ-ны **нөхцлийг** Байгаль орчин, нийгмийн амлалтын төлөвлөгөө, Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНАТ/БОНУАТ)-нд тусгах асуудлыг зээлдэгчид/харилцагчидтай тохиролцох.
6. Холбогдох оролцогч талуудтай **эртнээс, тасралтгүй, бүтээлчээр зөвлөлдөх**, Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС)-д нийцсэн төслийн түвшний гомдол барагдуулах механизмтай болоход нь зээлдэгч/ харилцагчдад дэмжлэг үзүүлэх.
7. БОНС, БОНАТ/БОНУАТ-нд нийцүүлэн төслийн амьдралын мөчлөгийн туршид **төслийн БОН-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг нягтлах, хяналт шинжилгээ хийх.**

Байгаль орчин, нийгмийн бодлого

Эрсдэлийг ангилах шинэ арга хандлага

- » Эрсдэлийг нягтлахдаа холбогдох стандарт, анхаарах эрсдэл, нөөцийн хэрэгцээг тодорхойлдог. Тухайн төсөлд бүх стандарт хамаарахгүй байж болно.
- » Байгаль орчин, нийгмийн эрсдлийн нэгдсэн байдлаар нягтлах, ангилах:
 - Шууд, шууд бус болон хуримтлагдсан нөлөөлөл
 - Салбарын онцлог эрсдэлт хүчин зүйлс
 - Хүмүүс, хүрээлэн буй орчны эмзэг, мэдрэмтгий байдал
- » Бусад эрсдэлийг мөн тооцох (Шинэ)
 - Нөхцөл байдлын эрсдэлт хүчин зүйл
 - Гүйцэтгэл / чадавхитай холбоотой эрсдэл
- » Төсөл эрсдэлийн нэг ангилалд хамаарна (БО, АНШ, НУИ-ийн хувьд тусад нь ангилахаа больсон)
- » Хамгааллын баримт бичиг нь эрсдэлийн ангилал, үүний дотор тухайн стандарттай холбоотой эрсдлийг тодорхойлох үндэс болно.



ХБББ-ийн ангилалтай хялбаршуулсан харьцуулалт
А ангилал (=Өндөр); В ангилал (=Томоохон эсхүл дунд); С ангилал (= Бага)

1. Эрсдэлд суурилсан дасан зохицох менежмент:

- ✓ Үнэлгээ, удирдлагын үйл явц нь байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн шинж чанар, цар хүрээтэй дүйцэхүйц байх
- ✓ Баримт бичгийг боловсруулах, баталсны дараа нийтлэхэд БОНАТ/БОНУАТ-ийг ашиглах

2. Зээлдэгчийн БОН-ийн тогтолцоог ашиглах

- ✓ Туршилт: холбогдох БОНС-ын зорилтуудтай "материалын нийцтэй байдал"
- ✓ Үнэлгээг төслийн түвшинд хийх. Төсөлтэй холбоотой БОНС-д харгалзан үзэж болно.
- ✓ Одоогийн "дүйцэхүйц" ба "хүлээн зөвшөөрөхүйц" байх шаардлагуудтай харьцуулахад чандлан мөрдөлт бага.

3. Нийтлэг арга хандлагыг ашиглах

- ✓ Туршилт: нийтлэг арга хандлага нь холбогдох БОНС-ын зорилгод дорвитой нийцэж байх ёстой.

4. Зөвлөлдөх хэлэлцүүлэг, оролцоо

- ✓ Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг Зээлдэгч/харилцагч бэлтгэх шаардлагатай (мэдээллийг ил тод нийтлэх, эмзэг бүлгүүд болон иргэдийг оролцуулан хүртээмжтэй байдлаар бүтээлчээр зөвлөлдөх)
- ✓ Эмзэг бүлэгт зориулсан ялгавартай арга хэмжээ авах тухай тодорхой шаардлага тавигдана, төсөл болон улс орны нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

5. Хяналт шинжилгээ:

- ✓ БОНАТ/БОНУАТ-нд заасан шаардлагын дагуу зээлдэгч/харилцагчийн төслийн байгаль орчны хамгааллын гүйцэтгэлд төслийн БОН-ийн эрсдэлд, нөлөөлөлд дүйцсэн хяналтыг АХБ тавина.

6. Мэдээллийн ил тод байдал:

- ✓ Үнэлгээ/зээл эцэслэн батлагдахаас өмнө.

Байгаль орчин, нийгмийн бодлого

Эмзэг бүлгийн эрсдэлийг шийдвэрлэх



Эмзэг бүлэг


Нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, нийгэм, иргэний болон эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлага, жендэрийн баримжаа, эдийн засгийн сул тал, нутгийн уугуул иргэний статус, байгалийн өвөрмөц нөөцөөс хараат байдлаасаа шалтгаалан төслийн сөрөг нөлөөлөлд илүүтэй өртөх эрсдэлтэй, төслийн үр өгөөжийг ашиглах чадвараараа бусдаас хязгаарлагдмал, зөвлөлдөх үйл явц, үр өгөөжийг хүртэхэд бүрэн оролцох боломжгүй/хасагдсан хувь хүн эсвэл хэсэг бүлэг хүмүүс.

1. **Эмзэг бүлгүүд** төслийн нөлөөлөлд илүүтэй өртөх ёсгүй
2. **Төслүүд нь үл ялгаварлан гадуурхлыг дэмжих ёстой бөгөөд "эмзэг" бүлгүүд төслөөс тэгш ашиг хүртэх ёстой.**
3. **Эмзэг байдал нь олон талтай бөгөөд салбар хоорондын харилцааг анхаарч үзэх хэрэгтэй.** Жишээлбэл, ядуурал, жендэр, хөгжлийн бэрхшээл хоорондын хамаарал.
4. **Ялгавартай арга хэмжээ нь эмзэг бүлэгт үзүүлэх нөлөөллийг арилгахад чиглэсэн байх ёстой.**
5. **Үнэлгээ, арга хэмжээний дизайн нь тухайн улсын нөхцөл байдал, хууль эрх зүйн орчин, түүнчлэн төслийн онцлог нөхцөл, эрсдэлийн түвшинд тохирсон мэдрэмжтэй хандлагыг баримтлах ёстой.**
6. **Хамгааллын арга хэмжээ нь эрсдэлийг удирдах, нөлөөлөлд өртсөн иргэдэд учирч болзошгүй хохирлыг арилгахад чиглэнэ.** Төслийн арга хэмжээ нь эрх зүйн өргөн хүрээтэй шинэчлэл хийх шаардлагыг илэрхийлэхгүй.
7. **Тухайн арга хандлага нь төслийн улмаас үүсч болзошгүй эрсдэлд эмзэг бүлгийн өртөмхий байдлыг нэмэгдүүлэхгүй байх ёстой.**
8. **Оролцогч талуудын оролцооны зохистой хэлбэр, гомдол барагдуулах аюулгүй, хүртээмжтэй механизмыг төслийн түвшинд бүрдүүлэх.**

Төслийн аль мөчлөгт БОН-ийн шаардлагууд хамаарах



ВЭ?



Хэлэлцүүлэг



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



Завсарлага



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



Хуралдаан 2: БОНС 1 ба БОНС 10-ын тойм

Зера Аббас

**АХБ-ны Хамгааллын алба (OSFG)-ны байгаль орчны
тэргүүлэх мэргэжилтэн**

Зарухи Хайрапетян

**АХБ-ны Хамгааллын алба (OSFG)-ны нийгмийн хөгжлийн
мэргэжилтэн (Хамгаалал)**




SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



Байгаль орчин, нийгмийн бодлого

Эрсдэлийг ангилах шинэ арга хандлага

- » Эрсдэлийг нягтлахдаа холбогдох стандарт, анхаарах эрсдэл, нөөцийн хэрэгцээг тодорхойлдог. Тухайн төсөлд бүх стандарт хамаарахгүй байж болно.
- » Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг нэгдсэн байдлаар нягтлах, ангилах:
 - Шууд, шууд бус болон хуримтлагдсан нөлөөлөл
 - Салбарын онцлог эрсдэлт хүчин зүйлс
 - Хүмүүс, хүрээлэн буй орчны эмзэг, мэдрэмтгий байдал
- » Бусад эрсдэлийг мөн тооцох (Шинэ)
 - Нөхцөл байдлын эрсдэлт хүчин зүйлс
 - Гүйцэтгэл / чадавхитай холбоотой эрсдэл
- » Төсөл эрсдэлийн нэг ангилалд хамаарна (БО, АНШ, УИ-ийн хувьд тусад нь ангилахаа больсон)
- » Хамгааллын баримт бичиг нь эрсдэлийн ангилал, үүний дотор тухайн стандарттай холбоотой эрсдэлийг тодорхойлох үндэс болно.



ХБББ-ийн ангилалтай хялбаршуулсан харьцуулалт
А ангилал (=Өндөр); В ангилал (=Томоохон эсхүл дунд); С ангилал (= Бага)



Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ ба менежмент

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлагууд

- 1. БОН-ийн нэгдсэн үнэлгээ:** байгаль орчин, нийгмийн хүчин зүйлсийг нэгтгэн БОН-ийн бүх шууд, шууд бус болон хуримтлагдсан эрсдэл, нөлөөллийг тусгах.
- 2. Байгаль орчин, нийгмийн хүчин зүйлс:** БОНС-д нийцүүлэх авч үзэх асуудлууд болон төслөөр өдөөгдсөн асуудлуудыг жагсаах.
- 3. Хамрах хүрээ:** Үнэлгээний цар хүрээ, холбогдох БОНС болон шаардлагуудыг тодорхойлох.
- 4. БОН-ийн үнэлгээ:** үнэлгээний түвшин нь БОН-ийн эрсдэл, нөлөөлөл болон холбогдох БОНС-д тохирсон байх.
- 5. Эмзэг бүлгүүд:** БОН-ийн үнэлгээгээр тодорхойлох бөгөөд улс орны нөхцөл байдал, төслийн шинж чанар, БОН-ийн эрсдэлд тулгуурлан ялгаатай арга хэмжээнүүдийг төлөвлөх.
- 6. БОН-ийн бэлэн байдал:** Холбогдох БОНС-ын дагуу БОН-ийн үнэлгээний бүх шаардлагуудыг тодорхойлж, АХБ-ны шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэхийг шаардах замаар сайжруулсан.
- 7. Байгаль орчин, нийгмийн үүрэг амлалт/үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНАТ/БОНУАТ):** дасан зохицох менежментийн үйл явцыг тодорхой хугацааны туршид БОНС-ын шаардлагад нийцсэн арга хэмжээнүүдийн хамт хэрэгжүүлэх. Төслийн хэрэгжилтийн явцад нийцлийг хангах арга хэмжээнүүдийг тусгах.
- 8. Мониторинг:** өндөр, томоохон эрсдэлтэй тохиолдолд хагас жил тутам, дунд, бага эрсдэлтэй тохиолдолд багадаа жил тутам, эсвэл БОНАТ/БОНУАТ-ний дагуу
- 9. Гүйцэтгэгчдийн удирдлага:** холбогдох БОНС-ууд болон БОНАТ/БОНУАТ-ний шаардлагыг гүйцэтгэгчид болон туслан гүйцэтгэгчид биелүүлэх



Оролцогч талуудын оролцоо, мэдээллийн ил тод байдал

Шинэ стандартууд болон сайжруулсан шаардлагууд

Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг

боловсруулах: бүх оролцогч талуудын аюулгүй, хүртээмжтэй оролцоог дэмжсэн бүтээлчээр зөвлөлдөх шаардлагуудыг тодорхойлох. Бие даасан баримт бичиг эсвэл хамгааллын бусад баримт бичгийн бүрдэл хэсэг байж болно.

Эмзэг бүлгүүдийг оролцогч талуудын оролцоотойгоор тодорхойлох бөгөөд тэдний хэрэгцээ, санал бодлыг хүлээн зөвшөөрч, оролцогч талуудын оролцоо, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл явц, гомдол барагдуулах механизмд тусгах.

Гомдлыг цаг алдалгүй барагдуулах, менежмент хийх үүднээс **Гомдол барагдуулах хүртээмжтэй механизмыг** төслийн эхэнд **бий болгох**.

Албадах, дарамтлах, айлган сүрдүүлэх, ялгаварлан гадуурхах зэрэг асуудлыг шийдвэрлэх тодорхой шаардлагуудыг тусгах, түүнийг арилгах зохих арга хэмжээг тусгах. Нэргүй гомдлыг шийдвэрлэх заалт оруулах.

Төслийн мэдээллийг аль болох эрт, төслийг бэлтгэх явцад, төслийн дизайны талаар оролцогч талуудтай бүтээлчээр зөвлөлдөх боломж олгохуйц хугацаанд, гэхдээ АХБ-ны төслийн үнэлгээ эсвэл зээлийг эцэслэн батлахаас өмнө **ил тод нийтлэх**.

Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө, үүний дотор мэдээллийн ил тод байдал, гомдол барагдуулах механизмын хэрэгжилтийг хангахад **хангалттай санхүүгийн болон хүний нөөцийг хуваарилах**.

Төслийн нарийн төвөгтэй байдалд үндэслэн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах, илэрсэн дутагдал, асуудлуудыг шийдвэрлэх зөвлөмжийг өгөх зорилгоор мэргэшсэн мэргэжилтнүүдийг татан оролцуулж болно.

Хэлэлцүүлэг



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



АХБ-ны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ)-ний төслийг хэлэлцэх Бүс нутгийн зөвлөлдөх уулзалт

*Зүүн Ази, Зүүн Өмнөд Ази, Шинэ Зеланд,
Австралийн Иргэний нийгмийн байгууллагууд*

2024 оны 2 дугаар сарын 5, 7, 9 | Цахим хурал



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



Хуралдаан 3: БОНС 5, БОНС 7, БОНС 8-ЫН ТОЙМ

Ирина Новикова

АХБ-ны Хамгааллын алба (OSFG)-ны нийгмийн хөгжлийн тэргүүлэх мэргэжилтэн

Тулси Бишт

АХБ-ны Хамгааллын алба (OSFG)-ны нийгмийн хөгжлийн ахлах мэргэжилтэн (Хамгаалал)

Зера Аббас

АХБ-ны Хамгааллын алба (OSFG)-ны байгаль орчны тэргүүлэх мэргэжилтэн



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE





Хамрах хүрээ: (i) Газрыг албадан чөлөөлөх/газар ашиглалтыг хязгаарлах, (ii) Газрыг сайн дурын үндсэн дээр арилжих, газар ашиглалтыг хязгаарлахтай холбоотой магадлан шинжилгээ хийх шаардлага, (iii) төсөл эхлэхээс өмнө хэрэгжүүлсэн, гэхдээ төслийг угтаж, эсвэл уг төслийг бэлтгэх явцад хэрэгжүүлсэн эсвэл эхлүүлсэн үйл ажиллагаа.

Эрсдэлийн үнэлгээ ба ангилал: Нэгдсэн БОННУ хийх, албадан нүүлгэн шилжүүлэлтийн ангилалд зориулсан бие даасан тоон босго тогтоохгүй (БОННУ-нд одоо нийт нөлөөлөл/эрсдэлийг авч үзнэ). БОНС 5-ыг хэрэглэх зорилгоор ГЧ/ГАХ-тай холбоотой нөлөөллийг цаашид ангилж болно.

Үйлчлэх хүрээ: БОНС1 болон БОНС5 Хамаарал бүхий байгууламжууд/ниймийн хуримтлагдсан нөлөөлөл/одоо байгаа байгууламжуудад зээлдэгч/харилцагчдын нөлөөлөл, хяналтанд байгаа ГЧ/ГАХ-тай холбоотой эрсдэл, нөлөөллийг бууруулах шаардлагатай; төслийг угтуулан болон бэлтгэх явцад өмнө хийгдсэн ГЧ/ГАХ ажиллагаанаас үүдэлтэй нөлөөлөл:

ГЧ/ГАХ-ын нөлөөлөл: (i) бүрэн, хэсэгчилсэн, байнгын болон/эсвэл түр зуурын эдийн засгийн болон байршлын нүүлгэн шилжүүлэлт хамаарна; (ii) тухайн улсын хуулийн дагуу газар ашиглах эрхгүй, албан ёсны, уламжлалт болон хүлээн зөвшөөрөгдөхүйц үл хөдлөх хөрөнгөгүй хэдий ч газрыг ашиглаж, газар дээр оршин амьдарч буй нөлөөлөлд өртсөн этгээдүүд хамарна.

Нөлөөллийн үнэлгээ: нөлөөлөлд дүйцсэн газар чөлөөлөх төлөвлөгөө (ГЧТ)-г боловсруулах, эмзэг бүлэг болон жендэрт онцгой анхаарал хандуулах, оролцогч талуудын оролцоог хангах, гомдол барагдуулах механизм бүрдүүлэх, мэдээллийг ил тод болгох.



Нөхөн олговор/Тусламж: төслийн нөлөөлөлд өртсөн этгээдүүдэд нөхөн олговор олгох, бусад дэмжлэг үзүүлэх. Байршлын хувьд нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийн шилжин суурьшсан газруудад аюулгүй байдлыг нь хангах, өмчлөх, эзэмших эрх бүхий зохистой орон сууцаар хангах.

Газар чөлөөлөх хүрээ (ГЧХ): АХБ төслийг батлах үед төслийн инженерийн зураг төсөл, эсвэл бүрэн үнэлгээ хийгдээгүй бөгөөд нөлөөлөл нь тодорхойгүй байвал нарийвчилсан хамрах хүрээ болон урьдчилсан төсөвт үндэслэн үндэслэлийг гаргасны дараа ГЧХ-г боловсруулж болно.

ГЧТ-ний мониторинг: барилгын ажил эхлэхээс өмнө ГЧТ-г хяналттайгаар хэрэгжүүлэх, төслийг хаах үед гүйцэтгэлийн хяналт хийх.

Ил тод байдал: бүх ГЧ/ГАХ-ийн арга хэрэгслүүдийг ил тод нийтлэх.

БОНС 7: Танилцуулга

- БОНС 7 нь ХБББ 2009-т одоо байгаа НУИ-ийн хамгаалал дээр үндэслэсэн бөгөөд **нутгийн уугуул иргэд** хүн амын хамгийн гадуурхагдсан, эмзэг бүлэгт багтдаг гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа. Тэд эдийн засаг, нийгэм, эрх зүйн байдлынхаа улмаас газар, байгалийн болон соёлын нөөцөө ашиглах эрхээ хамгаалах чадваргүй байдаг бөгөөд ертөнцийг үзэх үзэлдээ нийцүүлэн бүтээн байгуулалтад оролцох, үр шимийг нь хүртэх боломж нь хязгаарлагдмал байдаг.
- Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудад нутгийн уугуул иргэдийг уугуул үндэстний цөөнх, уугуул соёлын өв тээгчид, уугуул иргэд, абориген, уулын овог аймаг, цөөнх үндэстэн, овог аймгууд, овгийн бүлгүүд, ойн иргэд, анчин-түүвэрчид, малчид, бусад нүүдэлчдийн бүлгүүд гэх мэт өөр өөр нэр томъёогоор нэрлэдэг.



Зорилго: Эрх чөлөөтэйгээр, урьдчилан мэдэгдсэн, мэдээллээр хангагдсан зөвшөөрөл (FPIC)-ийг дэлгэрэнгүй тусгах

НУИ-ийг онцлог 4 шалгуураар тодорхойлно: (i) өөрийгөө тодорхойлох, (ii) газрыг шүтсэн хамтын амьжиргаа, (iii) уламжлалт зохион байгуулалт, хэм хэмжээ, (iv) өөрийн хэл. ("эмзэг байдлын" шалгуурыг хассан).

Өргөн хүрээний олон нийтийн дэмжлэг (BCS)-ийг Эрх чөлөөтэйгээр, урьдчилан мэдэгдсэн, мэдээллээр хангагдсан зөвшөөрөл (FPIC) зарчмаар сольсон: Дараах 3 нөхцөлд уг зарчим шаардлагатай: (i) төслөөс НУИ-ийн газар болон байгалийн нөөцөд сөрөг нөлөө үзүүлэх; (ii) тухайн газраас НУИ-ийг нүүлгэн шилжүүлэхэд хүргэх; (iii) НУИ-ийн өвөрмөц байдал, соёлд чухал ач холбогдол бүхий соёлын өв, амьдралынх нь зан үйл, оюун санаанд томоохон нөлөөлөл үзүүлэх.

Оролцоо ба бүтээлчээр зөвлөлдөх: нийгмийн эмзэг бүлгийнхэнд онцгой анхаарал хандуулж, НУИ-ийн оролцоотой хамтын шийдвэр гаргахад хангалттай хугацаа олгосон хүртээмжтэй үйл явц.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээ: биет бус нөлөөлөл, нөхцөл байдлын эрсдэл, биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээний холболтын үнэлгээ хийхийг шаарддаг.

Тайлбар: BCS = Өргөн хүрээний олон нийтийн дэмжлэг; FPIC = Эрх чөлөөтэйгээр, урьдчилан мэдэгдсэн, мэдээллээр хангагдсан зөвшөөрөл;

НУИ = нутгийн уугуул иргэд

Сайн дурын үндсэн дээр тусгаарлагдмал амьдарч буй НУИ: Ийм НУИ-ийн газар нутаг, нутаг дэвсгэр, соёлыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, хамгаалах, төслийн улмаас үүсч болзошгүй бүх хүсээгүй харилцаанаас зайлсхийх зохистой арга хэмжээг авах.

Төслийн үр шимийг хүртэгч нь зөвхөн НУИ байх, зөвхөн НУИ биш байх төслүүд: Аль ч тохиолдолд илүү тодорхой болгох.

Нутгийн уугуул иргэдийн төлөвлөгөө: нөлөөллийн үнэлгээ, бүтээлчээр зөвлөлдсөний үндсэн дээр, үнэлгээгээр төслөөс НУИ-дэд үзүүлэх нөлөөлөлд дүйцүүлэн боловсруулах.

Төсөв: НУИ-д олгох нөхөн олговор, нөлөөллийг бууруулах арга хэмжээнд хүрэлцэхүйц байх.

Гомдол барагдуулах механизм: НУИ-ийн маргааныг шийдвэрлэх уламжлалт механизмыг шаардлагатай тохиолдолд тусгасан, гомдол гаргагчдыг өс хонзонгоос хамгаалсан механизмыг бий болгох.

Хяналт, тайлагнал: төслийн эрсдэл, нөлөөлөлд дүйцсэн байх. Ихээхэн сөрөг нөлөө бүхий төслүүдэд мэргэшсэн, туршлагатай хөндлөнгийн хяналт шаардлагатай.



1. Соёлын биет бус нөөц ба харагдах байдалд үзүүлэх нөлөөлөл:

Соёлын **биет** болон **биет бус** өвд төслөөс үзүүлэх шууд болон хуримтлагдсан онцгой эрсдэл, нөлөөллийг удирдах.

2. Нутгийн уугуул иргэд: Нутгийн уугуул иргэдийн нутагтай давхцаж буй соёлын өв бүхий газар нутгийг хамруулах шаардлага тавигдана. Нутгийн уугуул иргэдийн нутагт соёлын өв илэрсэн тохиолдолд БОНС7-ийн дагуу Эрх чөлөөтэйгээр, урьдчилан мэдэгдсэн, мэдээллээр хангагдсан зөвшөөрөл (FPIC) шаардлагатай байж болно.

3. Төрөл бүрийн төрлийн соёлын өвд тавигдах тусгай шаардлага:

археологийн дурсгал болон материал, усан доорхи соёлын өв, булш бунхан, шарил, хөшөө дурсгал, ландшафт байгалийн нөөц, соёлын хөдлөх өвд хамаарна.

4. Оролцогч талуудын оролцоо:

соёлын өв, түүний ач холбогдлыг тодорхойлох, эрсдэл, нөлөөллийг үнэлэх, зайлсхийх, бууруулах арга, хяналт, тайлагналын хувилбаруудыг судлахын тулд бүтээлчээр зөвлөлдөх шаардлагатай.

Хуралдаан 4: БОНС 2, БОНС 4-ийн тойм

Феликс Оку

**АХБ-ны Хамгааллын алба (OSFG)-ны нийгмийн хөгжлийн
ахлах мэргэжилтэн (Хамгаалал)**



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE





Хөдөлмөр эрхлэлт ба хөдөлмөрлөх нөхцөл

Шинэ стандартууд болон сайжруулсан шаардлагууд

1. АХБ-ны ХБББ-ийн Хөрөнгө оруулалт хийхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт, Нийгмийн хамгааллын стратеги (2001), Хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээний гарын авлага, АХБ болон зээлдэгчийн хооронд байгуулсан төслийн хэлэлцээрийн заалтуудад тусгагдсан Хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээний талаархи тус банкны амлалтад тулгуурлан энэхүү стандартыг боловсруулсан.
2. Шаардлагуудын **үйлчлэх хүрээ** нь хөдөлмөр эрхлэлтийн төрөл, зээлдэгч болон төслийн ажилчдын хоорондын хөдөлмөрийн харилцааны шинж чанараас хамаарна.
3. **Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой эрсдэл** нь ихэвчлэн төслийн түвшинд **төвлөрөх** бөгөөд шаардлагууд нь бүх салбар, төслийн бүх ажилчдад хамаарна.

Бүх төрлийн хөдөлмөрийн харилцаанд хамаарна, үүнд:

- **шууд ажилчид** – төсөл дээр ажиллуулахаар зээлдэгч шууд ажиллуулсан, ажилд авсан ажилчид.
- **гэрээт ажилчид** – байршлаас үл хамааран төсөлтэй холбоотой ажил гүйцэтгүүлэхээр гуравдагч талын оролцуулсан, ажилд авсан ажилчид.
- **үндсэн ханган нийлүүлэгч ажилчид** – зээлдэгчийн үндсэн ханган нийлүүлэгчдийн авч ажилуулсан, ажилд авсан ажилчид.
- **үндсэн ханган нийлүүлэгчид** – төслийн бараа, материал, төслийн тодорхой үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үйлдвэрлэл/үйлчилгээний процесст ашиглах бараа, материалыг төсөлд шууд нийлүүлдэг ханган нийлүүлэгч.
- Орон нутгийн ажилчид – төслийн нөлөөлөлд өртсөн орон нутгаас зээлдэгч шууд ажилд авсан, хөдөлмөрийн төрөл бүрийн зохицуулалтын хүрээнд олон нийтийн хөгжлийн төсөлд хөдөлмөрөөрөө оролцож буй ажилчид.

❖ **Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө (ХМТ)** – Төсөл дэх хөдөлмөрийн асуудлыг зохицуулах системчилсэн арга хандлагыг тодорхойлох, үндэсний хууль тогтоомж, холбогдох хамтын гэрээ, БОНС2-ын шаардлагыг тусгах шинэ хэрэгсэл. ХМТ-д төслийн төрөл; ажиллах хүчний төрөл, хэмжээ, байршил; үндэсний хууль тогтоомж нь БОНС2-ын шаардлагыг хэр хангаж байгаа талаар нарийвчлан тусгана.



Хөдөлмөр эрхлэлт ба хөдөлмөрлөх нөхцөл

Шинэ стандартууд болон сайжруулсан шаардлагууд

4. Зорилго

- a. **Төслийн ажилтан, ажилчдад шударга хандах, үл ялгаварлах, эрх тэгш боломж олгох:** Ажилтан, ажилчдыг төсөлд ажиллуулахдаа ажилд авах, цалин хөлс олгох, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр эрхлэлтийн хугацаа, нөхцөл зэрэг хөдөлмөр эрхлэлтийн бүх асуудлаар тэдэнд шударга хандах, үл ялгаварлан гадуурхах, тэгш боломж олгох зарчмыг баримтална.
- b. **Төслийн ажилтан, ажилчдын эсрэг хүчирхийлэл, дарамт шахалт, дээрэлхэлт, айлган сүрдүүлэлт, мөлжлөгийн аливаа хэлбэр, үүний дотор бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамт (БМХД)-аас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх:** зээлдэгч нь төслийн хүрээнд аливаа хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх зохистой арга хэмжээг авна.
- c. ” **Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба хамтын хэлэлцээр хийх эрхийг хүндэтгэх:** эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба хамтын хэлэлцээр хийх эрхээ хэрэгжүүлэхийг хориглохгүй байхыг зээлдэгчээс шаардана. Тухайн улсын хууль эрх зүйн орчинг харгалзан үзнэ. Жишээ нь: БНХАУ-тай байгуулсан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хэлэлцээрийн заалтад: “...ажилчдыг санал гомдлоо илэрхийлэх, ажиллах орчин нөхцөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцлийнхөө талаар эрхээ хамгаалахаар хуулийн дагуу зөвшөөрөгдсөн арга хэрэгслийг ашиглахыг нь хязгаарлахгүй” гэж заасан.
- d. **Албадан хөдөлмөр болон хүүхдийн хөдөлмөрийг ашиглахаас урьдчилан сэргийлэх:*** бүх ажилчид, үүний дотор гол ханган нийлүүлэлтийн ажилтнууд, тэдгээрийн ханган нийлүүлэгчдийн түвшинд албадан хөдөлмөр болон хүүхдийн хөдөлмөрийг ашиглахыг хориглоно.
- e. **Төслийн ажилчид-удирдлага хоорондын ил тод харилцааг дэмжих, хөгжүүлэх, төлөвшүүлэх:** Төслийн ажилтан, ажилчдын төрлүүдийг тодорхойлох, холбогдох хөдөлмөрийн харилцааны хүрээнд БОНС болон тухайн улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тэднийг хэрхэн удирдахыг тодорхойлно.
- f. **Төслийн ажилтан, ажилчдад ажлын байртай холбоотой санал гомдлоо илэрхийлэх хүртээмжтэй механизмыг бүрдүүлэх:** хөдөлмөр эрхлэлт, ажиллах орчин нөхцлийн талаархи санал гомдлыг шийдвэрлэх гомдол барагдуулах механизмыг төслийн түвшинд байгуулах бөгөөд, түүнчлэн бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн дарамттай холбоотой асуудал, нууц гомдлыг барагдуулах, зохих хамгаалалтын механизмыг бүрдүүлнэ..

* дэлгэрэнгүй мэдээллийг дараагийн слайдуудад оруулсан болно




Хөдөлмөр эрхлэлт ба хөдөлмөрлөх нөхцөл

Шинэ стандартууд болон сайжруулсан шаардлагууд

ОУХБ-аас тодорхойлсон Хөдөлмөрийн үндсэн хэм хэмжээ болон Олон талт хөгжлийн санхүүгийн байгууллагуудтай уялдуулах

% Spread of Fundamental ILO Conventions Ratified by ADB DMCs



*NB: As of 19/01/2024



Хөдөлмөр эрхлэлт ба хөдөлмөрлөх нөхцөл

Шинэ стандартууд болон сайжруулсан шаардлагууд

Хүүхдийн хөдөлмөр (ОУХБ-ын C138 ба C182 конвенциудад нийцсэн): Зээлдэгч дараахь тохиолдолд хүүхдийг ажиллуулах, оролцуулахыг хориглоно:

- 15-аас доош насны (эсвэл тухайн улсын хөдөлмөрийн хуулийн дагуу 15-аас дээш нас) – бүх нийтийн боловсрол эзэмшиж төгсөх насанд хүрээгүй
- 18 нас хүрээгүй- эдийн засгийн хувьд мөлжлөгийн шинжтэй, эсвэл хүүхдийн боловсролд хор хохирол, саад учруулах, хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, сэтгэл зүй, ёс суртахуун, нийгмийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай бол хөдөлмөр эрхлүүлэхгүй байх.
- Үл хамаарах зүйл: 13-15 насныхан (i) эрүүл мэнд, хөгжилд нь хор хөнөөл учруулахгүй, (ii) сургуульд суралцах, мэргэжлийн чиг баримжаа олгох, сургалтын хөтөлбөрт оролцоход нь саад учруулахааргүй бол холбогдох олон улсын конвенцид нийцүүлэн хөнгөн ажил эрхэлж болно.

Албадан хөдөлмөр (ОУХБ-ын C029 ба C105 конвенциудад нийцсэн)

Тодорхойлолт

“Ямар нэг шийтгэл хүлээлгэхээр айлган сүрдүүлж аливаа этгээдээр гүйцэтгүүлэх, чингэхдээ уг этгээд нь өөрөө сайн дураар гүйцэтгэхийг санал болгоогүй бүх ажил болон үйлчилгээг хэлнэ .” (Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын C029 конвенцийн тодорхойлолт)

- Албадан хөдөлмөр эсвэл хөдөлмөрийн мөлжлөгийн бусад хэлбэрүүд илэрсэн тохиолдолд зээлдэгч нь төслөөс ийм практикийг арилгахын тулд залруулах арга хэмжээг цаг алдалгүй авна.
- Хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон аливаа хүнийг Зээлдэгч ажиллуулахгүй.

Албадан хөдөлмөрийн тухай, хүүхдийн хөдөлмөрийн тухай ОУХБ-ын конвенциудыг соёрхон баталсан байдал (АХБ-ны 39 ХБГО бөгөөд ОУХБ-ын гишүүн орнууд)*

| Албадан хөдөлмөр | | Хүүхдийн хөдөлмөр | |
|------------------|------|-------------------|------|
| C029 | C105 | C138 | C182 |
| 36 | 32 | 35 | 40 |



Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал

Шинэ стандартууд болон сайжруулсан шаардлагууд

- 1. Орон нутгийн иргэд, төслийн ажилчдын аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал:** Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой эрсдэл, үүний дотор орон нутгийн иргэд, төслийн ажилчдад учирч болзошгүй эрсдэл, зам тээврийн хөдөлгөөний аюулгүй ажиллагаа, байгалийн аюул зэрэг нөлөөллийн үнэлгээ, төлөвлөлт, удирдлага, хяналт шинжилгээ.
- 2. Ослыг мэдээлэх, ослын менежмент**
- 3. Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, дарамт (БМХД):** Ажилчид болон нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн хувьд төсөлтэй холбоотой БМХД-ын эрсдлийг тодорхойлох, шийдвэрлэх, менежмент хийх удирдах шаардлага Зээлдэгчид тавигдана.
- 4. Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээ:** Онцгой байдал үүсгэж болзошгүй төслүүдийн эрсдлийн аюулын үнэлгээг хийж, яаралтай хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулна.
- 5. Хариуцах хамгаалалтын ажилтнууд:** Ажилчид болон эд хөрөнгийг хамгаалах зорилгоор хамгаалалтын ажилтнуудыг хөлсөлсөн тохиолдолд тэд иргэд, ажилчдад аюул занал учруулах ёсгүй.
- 6. Дэд бүтцийн дизайн ба аюулгүй ажиллагаа:** Төслийн бүтцийн элементүүдийг тухайн улсын аюулгүй ажиллагааны шаардлага эсвэл салбарын сайн туршлагад нийцүүлэн хангаж, хэрэглэгчдийн нас, чадвар, хөгжлийн бэрхшээлд тохирсон шийдлүүдийг тусгана.
- 7. Далангийн аюулгүй ажиллагаа:** шинэ эсвэл одоо байгаа далангийн төслүүдийн хувьд далангийн аюулгүй ажиллагааны шаардлагыг мөрдөнө.

❖ **Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежментийн төлөвлөгөө (ЭМААМТ)** - Төсөл дэх эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын эрсдлийг удирдах системчилсэн хандлагыг тодорхойлно. Төслийн төрөл, ажиллах хүчний төрөл, хэмжээ, байршил, ойр орчмын иргэдэд үзүүлэх эрсдэлс хамааран **ХАБЭА, Олон нийтийн ЭААБ** болон Аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөөний үндэс зэргийг багтааж болно.

Хэлэлцүүлэг



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



АХБ-ны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ)-ний төслийг хэлэлцэх Бүс нутгийн зөвлөлдөх уулзалт

*Зүүн Ази, Зүүн Өмнөд Ази, Шинэ Зеланд,
Австралийн Иргэний нийгмийн байгууллагууд*

2024 оны 2 дугаар сарын 5, 7, 9 | Цахим хурал



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



Хуралдаан 5:

БОНС 3, БОНС 6, БОНС 9-ийн тойм

Зера Аббас

*АХБ-ны Хамгааллын алба (OSFG)-ны байгаль
орчны тэргүүлэх мэргэжилтэн*



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE





Нөөцийн хамгаалал, бохирдлоос сэргийлэх

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлагууд

- 1. Нөөцийн хэмнэлт:** нөөцийн хэмнэлтийг сайжруулах, эрчим хүч, ус, хөрс, бүх төрлийн түүхий эдийн нөөцийн ашиглалтын эрчмийг багасгах арга хэмжээг хэрэгжүүлэх.
- 2. Тойрог эдийн засаг:** тойрог буюу хаягдалгүй эдийн засгийн зарчмуудыг төслийн бүх тал дээр мөрдөх.
- 3. Хог хаягдал, химийн бодис:** аюултай болон аюулгүй хог хаягдлыг шууд болон шууд бусаар үүсгэх, химийн аюултай бодис, бодис, материалыг үйлдвэрлэх, худалдаалах, ашиглахтай холбоотой тодорхой шаардлагууд.
- 4. Пестицид:** пестицидийн хэрэглээг багасгах, удирдахад шаардлагатай шинэчлэгдсэн шаардлагууд.
- 5. Бохирдлоос урьдчилан сэргийлэх удирдамж:** Дэлхийн банк группийн Хүрээлэн буй орчны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамжийг үндэсний хэм хэмжээ болон/эсвэл салбарын сайн туршлагын (GIP) хамт үргэлжлүүлэн хэрэгжүүлэх. (Зөрүүтэй тохиолдолд илүү хатуу шаардлагатайг нь мөрдөнө).



Биологийн олон янз байдал, байгалийн нөөцийн тогтвортой менежмент

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлагууд

1. **Амьдрах орчны төрлүүдийн ангилал:** Амьдрах орчныг өөрчлөгдсөн эсвэл байгалийн унаган гэж ангилах бөгөөд амьдрах нэн чухал орчин байгаа эсэхийг тодорхойлохдоо биологийн олон янз байдлын болзошгүй чухал бүрдэл хэсгийг үнэлгээгээр тодорхойлох.
2. **Амьдрах орчныг хамгаалах:** биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн менежментийг бэхжүүлэх
3. **Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг шийдвэрлэх:**
 - (i) өөрчлөгдсөн болон байгалийн унаган амьдрах орчны хувьд цэвэр алдагдалгүй байх
 - (ii) нэн чухал бүрдэл хэсэгт цэвэр ашигтай байхыг эрхэмлэх,
 - (iii) чухал амьдрах орчинд цэвэр ашигтай байх
4. **Гол ханган нийлүүлэгчид:** байгалийн нөөцийн гол ханган нийлүүлэгчид, тэдний ажиллуулж буй ханган нийлүүлэгчдийг үнэлэхэд эрсдэлд суурилсан тогтвортой нөөцийн худалдан авалт, менежмент ба баталгаажуулалтын журмыг баримтлах.
5. **Хориотой бүс:** Alliance for Zero Extinction Sites (AZEs), ЮНЕСКО-гийн Дэлхийн байгалийн болон хосолмол өв бүхий газар, 500 км-ээс дээш урттай чөлөөт урсгалтай гол мөрөн дээр төслийн бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэхийг хориглоно.
6. **Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал эцсийн арга зам байх:** биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллыг зөвхөн эцсийн арга зам гэж үзэх бөгөөд төслийн бүх боломжит хувилбаруудыг өмнө нь судалж, төслийн “дүйцүүлэн хамгаалагдах чадварыг” тогтоох шаардлагатай.



Уур амьсгалын өөрчлөлтөд АХБ-ны баримталж буй хандлага

- **АХБ-ны төслийн багц болон төслийн түвшинд** Парисын хэлэлцээрийн зорилтуудтай нийцүүлэх
- **ХБББ-ийн байгаль орчны хамгаалал** нь төслийн түвшний хүлэмжийн хийн ялгарлын үнэлгээ, менежмент (босго 100,000 т/CO₂ экв/жил) хийхийг шаарддаг.
- **АХБ төслийн түвшний уур амьсгалын эрсдэлийн шинжилгээ** уур амьсгалын эрсдэл, дасан зохицох үнэлгээг хийдэг

Хүлэмжийн хийг бууруулах

- Төсөлтэй холбоотой хүлэмжийн хийн ялгарал: Төсөлтэй холбоотой хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох, хянах, тайлагнах
- Төсөл хэрэгжихээс өмнөх хүлэмжийн хийн үнэмлэхүй ба харьцангуй ялгарлын урьдчилсан тооцоог хийх
- Босго: хүлэмжийн хийн үнэмлэхүй ба харьцангуй ялгаруулалт - 20,000 тонноос +20,000 tCO₂e/жил хооронд байвал босго нь 20,000tCO₂e/жил
- >20,000 tCO₂e/жил ялгарлын хувьд хүлэмжийн хийн үнэмлэгүй ялгарлыг жил бүр мониторинг хийж, АХБ-нд тайлагнана

Уур амьсгалын эрсдэл

- **Уур амьсгалын эрсдэлийн ерөнхий үнэлгээ/скрининг:** төслийн түвшинд уур амьсгалын эрсдэлийн скрининг хийх.
- **Уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ:** уур амьсгалын үнэлгээг хийж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх арга хэмжээг боловсруулах

Хуралдаан 6: Санхүүжилтийн төрлүүд, бүтээгдэхүүнд тавигдах БОН-ийн шаардлагууд, Хөрөнгө оруулалт хийхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт

*Такако Морита, АХБ-ны Хуулийн алба (OGC)-ны
Тэргүүлэх хуульч*



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



Санхүүжилтийн нийт хэлбэрүүдэд хамгааллын бодлогыг ашиглах

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлага

Санхүүжилтийн төрлүүд, бүтээгдэхүүнд тавигдах шаардлагууд

Үйлчлэх хүрээ: АХБ болон зээлдэгч/ харилцагчийн санхүүжилтийн бүх хэлбэр, бүтээгдэхүүнд тавигдах БОН-ийн шаардлагыг нэгтгэдэг. Үүнд:

- салбарын зээл, яаралтай тусламжийн зээл, олон шатлалт санхүүжилийн зээлийн шугам (ОШСЗШ)
- бодлогод суурилсан зээл (БЗ) болон салбарыг хөгжүүлэх хөтөлбөрүүд
- үр дүнд суурилсан зээл (ҮДСЗ)
- төслийн бэлэн байдлыг хангах санхүүжилт, жижиг зардлыг санхүүжүүлэх хөтөлбөр, техникийн туслалцаа (ТТ)
- санхүүгийн зуучлагч (СЗ) болон корпорацийн санхүүжилт

- БОН-ийн бодлого болон БОНС1 нь ирээдүйн санхүүжилтийн хэлбэр, бүтээгдэхүүнийг чиглүүлэхэд туслах БОН-ийн үнэлгээ, удирдлагын арга барилыг тодорхойлсон.
- Бодлогын зарчмуудын тухайд санхүүжилтийн төрлүүд, бүтээгдэхүүнд хамаарах БОН-ийн эрсдэл, нөлөөллийг удирдах талаар АХБ-ны хүлээх үүрэг, зээлдэгч/ харилцагчдад тавигдах шаардлагуудыг тодорхойлсон бие даасан баримт бичгүүд бий.
- ТТ-ны хамрах хүрээ нь БОН-ийн эрсдэл бүхий туршилтын үйл ажиллагаа болон бодлогын шинэчлэлээр хязгаарлагдана.
- Санхүүгийн зуучлагч болон корпорацийн санхүүжилтийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан .

Санхүүжилтийн нийт хэлбэрүүдэд хамгааллын бодлогыг ашиглах

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлага

Бодлогод суурилсан зээл/Бодлогын зээл

- Улсын төсвөөс санхүүжих тодорхой зардалд бус харин бодлогын арга хэмжээнүүдийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ, менежментэд чиглэгддэг.

АХБ-ны хүлээх үүрэг:

- Бодлогын арга хэмжээнүүдээс үүдэн бий болох БОН-ийн эрсдэл, нөлөөллийг үндэслэн бодлогын матрицыг эцэслэн боловсруулахаас өмнө тухайн бодлогын арга хэмжээний эрсдэлийг ангилах.
- Нөхцөл байдлын хүчин зүйл эсвэл салбарын онцлог эрсдэлийг тодорхойлох.
- Зээлдэгчийн санал болгож буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг АХБ хянан үзнэ.

Зээлдэгчид тавигдах шаардлага:

- Санал болгож буй бодлогын арга хэмжээнүүдтэй холбоотойгоор үүсэх **БОН-ийн шууд** болон **шууд бус эрсдэл, нөлөөллийг** тодорхойлох, үнэлэх
- Холбогдох БОНС-тай материаллаг нийцэл бүхий зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд эрсдэл, нөлөөлөлтэй дүйцэхүйц бууруулах арга хэмжээг бодлогын арга хэмжээний эцсийн дизайнд тусгах.**
- Бодлогын зээлийн үйл ажиллагааны цар хүрээ, шинж чанартай холбоотой стратеги, газарзүй, салбарын хэмжээний аливаа ноцтой эрсдэл илэрсэн тохиолдолд бодлогын дизайн болон БОН-ийн менежментэд тусгах зорилгоор **Зээлдэгч байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ зэрэг нэмэлт үнэлгээг хийнэ.**

Санхүүжилтийн нийт хэлбэрүүдэд хамгааллын бодлогыг ашиглах

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлага

Үр дүнд суурилсан зээл

- БОНС-уудад нийцсэн зорилгод хүрэхэд **Үр дүнд суурилсан зээл (ҮДСЗ)-ийн хөтөлбөрийн тогтолцоо** зохистой эсэхийг дүгнэхэд байгаль орчин, нийгмийн үнэлгээ, менежмент чиглэгдэнэ.

АХБ-ны хүлээх үүрэг:

- АХБ-ны санхүүжилтээр хэрэгжих **ҮДСЗ-ийн хөтөлбөрийн** эрсдэлийн ангиллыг зээлдэгчийн хэрэгжүүлэх чадавхи болон нөхцөл байдлын бусад эрсдэлийг харгалзан тодорхойлох.
- ҮДСЗ хөтөлбөрт хамаарах БОНС-ыг хангаж ажиллахыг Зээлдэгчээс шаардах.
- ҮДСЗ хөтөлбөрийн шинж чанар, хамрах хүрээ, эрсдэлийн ангилалтай дүйцүүлэн ҮДСЗ-ийн хөтөлбөрийн системүүдэд Хөтөлбөрийн хамгааллын системийн үнэлгээг (ХХСҮ) хийх.

- Урьдчилан тооцоолоогүй нөлөөлөл эсвэл одоо байгаа нөлөөллийг удирдах, бууруулах зээлдэгчийн чадавхи, амлалтын үнэлгээг ХХСҮ-нд тусгана. Үүнд мөн ҮДСЗ-ийн хөтөлбөрт хамаарах БОН-ийн шаардлагуудыг хэрэгжүүлэх зээлдэгчийн чадвар, чадавхид сөргөөр нөлөөлж болзошгүй хөтөлбөрийн, институцийн болон нөхцөл байдлын эрсдлийг тодорхойлоно.
- АХБ төслийн үнэлгээг хийхээсээ өмнө ХХСҮ-г нийтэлж, ҮДСЗ-ийн хөтөлбөрийн оролцогч талуудтай зөвлөлдөнө.
- **Өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэнээс бусад бүх үйл ажиллагаа** ҮДСЗ-ийн хөтөлбөрт хамрагдах боломжтой.

Санхүүжилтийн нийт хэлбэрүүдэд хамгааллын бодлогыг ашиглах

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлагууд

Үр дүнд суурилсан зээл

Зээлдэгчид тавигдах шаардлага:


- ҮДСЗ-ийн хөтөлбөрийн тогтолцоог ашиглан тус хөтөлбөртэй холбоотой БОНС-уудын зорилтуудыг хэрэгжүүлэх.
- Хөтөлбөрийн хамгааллын системийн үнэлгээ (ХХСҮ)-нд оршиж буй АХБ-ны илрүүлсэн, Эрсдэлийн удирдлагын нэгдсэн төлөвлөгөө болон Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (ХҮАТ)-нд тусгагдсан хийдлийг арилгах арга хэмжээний талаар АХБ-тай зөвшилцөх.
- Зээлдэгч нь АХБ-ны санхүүжилттэй ҮДСЗ-ийн хөтөлбөрийн үйл ажиллагааг үнэлж, өндөр эрсдэлтэй ангилалд орж болзошгүй болон АХБ-ны Хөрөнгө оруулалт хийхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалтад багтсан үйл ажиллагааг оруулахгүй байх.
- Зээлдэгч нь эрсдэлийн удирдлагын нэгдсэн төлөвлөгөө болон Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (ХҮАТ)-ний хэрэгжилтэд хяналт тавьж, мониторингийн тайланг АХБ-нд хүргүүлэх.
- ҮДСЗ-ийн хөтөлбөр БОН-ийн шаардлагад нийцээгүй тохиолдолд Зээлдэгч зөрчлийг арилгах хугацаатай арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, АХБ-тай тохиролцох.

Санхүүжилтийн нийт хэлбэрүүдэд хамгааллын бодлогыг мөрдөх

Санхүүгийн зуучлагчдын эрсдэлийн ангилал

Хэлцлийн хүрээнд СЗ гэсэн ангилалд багтсан “СЗ”-ыг АХБ-ны санхүүжилттэй бүх зээлийн багцийн БОН-ийн эрсдэлийн шинж чанараас хамааран дараах дэд ангиллуудад хуваана.

Өндөр эрсдэлтэй хэлцэл



СЗ-1: олон янзын, нөхөн сэргээгдэх боломжгүй эсвэл урьд өмнө хэзээ ч байгаагүй их хэмжээний сөрөг нөлөөлөл, эрсдэлтэй бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэх

СЗ-2: Цөөн тооны, ерөнхийдөө тухайн газар нутгийг хамарсан, үндсэндээ нөхөн сэргээгдэх боломжтой, бууруулах арга хэмжээ авах замаар шийдвэрлэх боломжтой БОН-ийн болзошгүй хязгаарлагдмал сөрөг нөлөөлөл; эсвэл олон янзын, нөхөн сэргээгдэх боломжгүй эсвэл урьд өмнө тохиолдож байгаагүй байгаль орчны болон нийгмийн томоохон сөрөг эрсдэл, нөлөөлөл бүхий маш хязгаарлагдмал тооны бизнесийн үйл ажиллагаа багтана.

СЗ-3: байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн бага буюу огт байхгүй бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэх.

Өндөр эрсдэлтэй хэлцэл- БОН-ийн өндөр эсвэл томоохон эрсдэлтэй багц, арга хэмжээ хэлцэл бүхий СЗ-ид. (СЗ-1 болон СЗ-2 багцын үзүүлэлтийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хамарсан). АХБ-ны санхүүжилттэй эдгээр хэлцлүүдэд БОНС-ыг мөрдөнө.

Санхүүжилтийн нийт хэлбэрүүдэд хамгааллын бодлогыг ашиглах

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлагууд

Санхүүгийн зуучлагчид (FI)

АХБ-ны хүлээх үүрэг:

- Магадлан судалгаа хийж, БОН-ийн эрсдэлийн ангиллыг тодорхойлох, СЗ-д ашиглах Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС)-ийн хэрэгцээ, зохист байдлыг нягтлан, удирдамж чиглэл өгөх.
- СЗ-ын холбогдох мэдээлэл (жишээ нь, БОНМС-ийн хураангуй, мониторингийн тайлан, холбогдох үнэлгээ, менежментийн хэрэгслүүд)-ийг хянах, нийтлэх
- АХБ-ны санхүүжилттэй өндөр эрсдэлтэй бүх хэлцлийг хянах.

Санхүүгийн зуучлагчдад тавигдах шаардлага:

- АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагаа, хэлцэлтэй холбоотой БОН-ийн эрсдэл, нөлөөллийн шинж чанар, цар хүрээтэй дүйцэхүйц БОНМС-ийг СЗ-1 болон СЗ-2 боловсруулах. СЗ-3-ын хувьд БОН-ийн ерөнхий үнэлгээ/скринингээр БОН-ийн эрсдэл бага эсвэл сөрөг нөлөөгүйг нотолсон байх.
- **Өндөр эрсдэлтэй хэлцэл:** АХБ-ны санхүүжилттэй ийм бүх хэлцлүүдийг тус банкаар хянуулах, зөвшөөрөл авах, мэдээллийн ил тод байдлыг хангах; АХБ-ны санхүүжилттэй ийм бүх үйл ажиллагаа, хэлцлүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг мониторингийн тайланд тусгах.
- Оролцогч талуудын оролцоог хангах, гомдол барагдуулах механизм, ажилчдад аюулгүй, эрүүл ажиллах орчныг бүрдүүлэх.

Санхүүжилтийн нийт хэлбэрүүдэд хамгааллын бодлогыг ашиглах

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлагууд

Корпорацийн санхүүжилт

АХБ-ны хүлээх үүрэг:

- Магадлан судалгаа хийж, БОН-ийн эрсдэлийн ангиллыг тодорхойлох.
- Корпорацийн санхүүжилт авч буй харилцагчийн Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС)-ийн хэрэгцээ, зохист байдлыг нягтлан, удирдамж чиглэл өгөх
- Холбогдох мэдээлэл (жишээ нь, БОНМС-ийн хураангуй, мониторингийн тайлан, холбогдох үнэлгээ, менежментийн хэрэгслүүд)-ийг хянах, нийтлэх

Корпорацийн санхүүжилтийн харилцагчдад тавигдах шаардлага :

- АХБ-ны санхүүжилттэй БОН-ийн хувьд өндөр, томоохон, дунд эрсдэл, нөлөөлөл бүхий үйл ажиллагаа, хэлцлүүдэд БОН-ийн эрсдэл болон нөлөөллийн шинж чанар, цар хүрээтэй дүйцэхүйц БОНМС-ийг боловсруулах.
- Тодорхойлсон үйл ажиллагаа, хэлцэл, хувьцааны хөрөнгө оруулалтад тавигдах болон бусад ерөнхий шаардлагууд.
- Оролцогч талуудын оролцоог хангах, гомдол барагдуулах механизм, ажилчдад аюулгүй, эрүүл ажиллах орчныг бүрдүүлэх.

Бусад системийг ашиглах үед тавигдах хамгааллын шаардлагууд

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлагууд

Зээлдэгчдийн БОН-ийн тогтолцоог бэхжүүлж, БОН-ийн гүйцэтгэлийг сайжруулах нь БОН-ийн бодлогын зорилтуудын нэг юм.

- ЗГ-ны үйл ажиллагаанд АХБ зээлдэгчийн БОН-ийн тогтолцоо нь БОНС-т дорвитой нийцсэн зорилтуудыг хангахуйц, төслийн эрсдэлийг удирдах чадавхитай гэж үзвэл уг тогтолцоог АХБ ЗГ-ын үйл ажиллагаанд ашиглаж болно.
- Зээлдэгчийн БОН-ийн тогтолцоог ашиглаж байгаа ч АХБ-ны БОН-ийн бодлогод тусгагдсан тус банкны хариуцах үүрэг болон АХБ-ны Хариуцлагын механизмын бодлогыг даврах мөрдөнө.
- Зээлдэгчийн БОН-ийн тогтолцоог бүхэлд нь эсвэл хэсэгчлэн авч үзэж болох бөгөөд дорвитой нийцлийг төслийн түвшинд тодорхойлно.
- Хийгдэх үнэлгээгээр дорвитой нийцлийг тодорхойлох үүднээс оролцогч талуудын байр суурийг үнэлгээнд тусгахуйц байдлаар АХБ оролцогч талуудтай хамтран ажиллана. Үнэлгээг АХБ-ны цахим хуудсанд нийтлэнэ.
- Үнэлгээгээр аливаа дутагдал хийдэл илэрсэн тохиолдолд тэдгээрийг арилгах, зээлдэгчийн БОН-ийн тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээ авна (энэ нь Байгаль орчин, нийгмийн амлалтын төлөвлөгөө (БОНАТ)-ний бүрдэл байж болно).
- Ийм арга хэмжээ нь зээлдэгч, холбогдох үндэсний, орон нутгийн, эсвэл салбарын хэрэгжүүлэгч байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх асуудлыг шийдэхүйц байж болно.

Бусад системийг ашиглах үед тавигдах хамгааллын шаардлагууд

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлагууд

Төслийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд хамтарсан санхүүжилтийн нийтлэг арга хандлагыг БОНХ-нд тусгасан.

- АХБ бусад олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны байгууллагуудтай төслийг хамтран санхүүжүүлж байгаа тохиолдолд АХБ болон зээлдэгч нь төслийн үнэлгээ, боловсруулалт, хэрэгжилтэд мөрдөх **нийтлэг арга хандлага** – нэг багц шаардлагыг тохиролцож болно.
- **БОНС-д нийцсэн зорилгод дорвитой хүргэхүйц** байж чадвал ийм нийтлэг хандлагыг хүлээн зөвшөөрнө.
- Төсөлд мөрдөхөөр харилцан тохиролцсон нийтлэг арга хандлагыг Байгаль орчин, нийгмийн амлалтын төлөвлөгөө (БОНАТ)-нд тусгах бөгөөд БОН-ийн гүйцэтгэлийг нийтлэг арга барилтай харьцуулан хэмжинэ.
- Түүнчлэн, бусад олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны байгууллагууд БОН-ийн үнэлгээ, менежментийн ажлыг аль хэдийн гүйцэтгэсэн төслийг АХБ санхүүжүүлж байгаа тохиолдолд хэрэв эдгээр шаардлага нь холбогдох БОНС-д нийцсэн зорилтуудыг хэрэгжүүлэх боломжийг олгохуйц байх тохиолдолд АХБ үг үнэлгээ, үр дүнг ашиглаж болно (**харилцан найдах зарчим**).

Шинэ заалтууд болон сайжруулсан шаардлагууд

- Хөрөнгө оруулалт хийхийг хориглосон үйл ажиллагааны жагсаалт (PIAL)-д АХБ-ны санхүүжилтийн шаардлагыг хангахгүй үйл ажилланууд багтдаг .
- ОТХБ-ууд үл хамаарах зүйлсийн талаар өөр өөр зарчимтай байдаг; заримд нь тодорхой жагсаалт байдаггүй бол заримынх нь жагсаалт илүү өргөн хүрээтэй байдаг.
- Санал болгож буй бодлогод ийм үйл ажиллагааны жагсаалтыг хэвээр үлдээхийн зэрэгцээ **АХБ-ны Эрчим хүчний бодлогод (2021)** тусгагдсан шинэ хоригуудыг нэмж оруулсан болно. Үүнд (i) нүүрсээр ажилладаг цахилгаан станц болон нүүрсээр ажилладаг дулааны станцууд; (ii) нүүрс олборлох, боловсруулах, хадгалах, тээвэрлэх; (iii) газрын тосны анхан, дунд шатны төслүүд; (iv) байгалийн хийн хайгуул, өрөмдлөг.
- Шинэ бодлогын дагуу асбестын утас үйлдвэрлэх, худалдаалах, ашиглах үйл ажиллагааг санхүүжүүлэхийг бүрэн хориглосон. Энэ нь 20% -иас бага асбестын агууламж бүхий асбест цементэн наамал хавтанг ашиглахыг зөвшөөрдөг одоогийн ХБББ-т орж буй өөрчлөлт юм. Одоо ашиглаж буй асбестыг зайлуулж устгах зохистой менежментийн төлөвлөгөө бүхий төсөлд энэхүү хориг хамаарахгүй.

Хэлэлцүүлэг



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



Хаалтын үг

Брюс Данн *АХБ-ны Хамгааллын алба (OSFG)-ны* *захирал*



SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE



Баярлалаа!

<https://www.adb.org/who-we-are/about/safeguard-policy-review>
WEBPAGE

<https://www.facebook.com/ADBsafeguardreview>
FACEBOOK PAGE

safeguardsupdate@adb.org
E-MAIL



**SAFEGUARD
POLICY REVIEW
AND UPDATE**

